

АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БУС, ХҮНД СУРТАЛ, ЧИРЭГДЭЛТЭЙ БАЙДЛЫН ТАЛААР ИРГЭДИЙН ГОМДОЛ, САНАЛ ХҮЛЭЭН АВАХ 1977 УТАСНЫ 08-Р САРЫН ТАЙЛАН

Мониторинг судалгааны товч танилцуулга

“ГЛОБ ИНТЕРНЭШНЛ” ТББ нь Авилгатай Тэмцэх Газартай /цаашид АТГ гэх/ хамтарч 2007 оны долдугаар сарын 01-ээс эхлэн 6 сарын хугацаатай “Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал” мониторингийн төслийг Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр хэрэгжүүлж эхлээд нэг сар болж байна.

АТГ-аас төрийн байгууллагуудын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгох, иргэдийн оролцоог хангах талаар 18 зүйл бүхий зөвлөмж бичиг боловсруулж 2007 оны дөрөвдүгээр сард төрийн байгууллагуудад хүргүүлсэн билээ.

Дээрх зөвлөмжийн хэрэгжилт ямар түвшинд байгааг тандах зорилгоор төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх байгууллагад ажиглалт, сурвалжлагын болон баримт бичгийн судалгаа хийлээ.

Мөн төслийн хүрээнд төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд гарсан зөрчлийн талаархи гомдол саналыг хүлээн авах 1977 /энгийн ярианы тарифтай/ утсыг нээлттэй ажиллуулан ирсэн мэдээллийг судлан үзэж, тухайн байгууллагын удирдлагад АТГ-аас үйл ажиллагаандаа гаргасан зөрчилөө нэн даруй арилгах арга хэмжээ авч, эргэж мэдээллэхийг сануулсан шаардлага хүргүүлэн ажиллаж байна.

1977 утсаар 2007 оны 07 дугаар сарын 09–нөөс эхэлж, энэ оны 12 сар дуустал иргэдээс төрийн байгууллагын хүнд суртал, төрийн үйлчилгээний ил тод байдлын талаар гомдол саналыг хүлээн авч сар бүрийн 05-ын дотор иргэдээс ирсэн гомдол саналыг нэгтгэн АТГ болон өөрийн вэб сайтаараа олон нийтэд мэдээллэж байна.

2007 оны 08 дугаар сарын 01-ээс 31 хүртэлх хугацаанд 1977 утсаар иргэдээс нийт 83 гомдол, 5 саналыг авч цаг тухайд АТГ-т хүргүүллээ.

Гомдол өгсөн иргэдийн 75 нь Улаанбаатар хотоос, 8 нь хөдөө орон нутгаас холбогдож мэдээлэл өгсөн.

83 иргэний 44 нь өмнө нь тухайн байгууллага албан тушаалтанд дийлэнх хувь нь одоо хандаж байгаагаар ижил зорилгоор, үлдсэн хувь нь өөр бусад зорилгоор зохих журмын дагуу нэг иргэн дунджаар 4.6 удаа очиж байсан хэдий ч тэд бүгд авах ёстой үйлчилгээгээ авч чадаагүй нь хангалтгүй үзүүлэлт юм. Энэ сард холбогдсон иргэдийн дийлэнх нь замын цагдаагын газар, засаг даргын тамгийн газар, газрын албадад хандаж байсан байна.

Байгууллагын тухай мэдээлэл

Хандсан иргэдийн 20 хувь нь улсын, 14 хувь нь нийслэлийн, 48 хувь нь дүүрэг сумдын, 18 хувь нь баг хорооны хэмжээнд үйл ажиллагаагаа иргэдэд хүргэдэг төрийн байгууллагад хандсан. Өмнөх сард хандсан иргэдтэй харьцуулбал улс, аймаг нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаагаа иргэдэд хүргэдэг байгууллагуудын эзлэх хувь өмнөх сараас цөөрч, дүүрэг сумдын болон баг хороодын байгууллага, албан тушаалтанд гомдол дийлэнх хувийг эзэлж байна.

Иргэдийн гомдол гаргасан төрийн байгууллагуудыг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл 21 хувь нь засаг даргын тамгийн газарууд, 11 хувь нь замын цагдаагийн газар албад, 11 хувь нь газрын албадуудын ажилтан, албан тушаалтанууд иргэдийг илүү чирэгдүүлж байна гэсэн мэдээлэл өгсөн.

Сум дүүргийн засаг даргын тамгийн газарууд, замын цагдаагийн газарууд, газрын албад иргэдийг ихээр чирэгдүүлж байна.

Албан тушаалтны тухай мэдээлэл

Утсаар өгсөн гомдол нь тухайн байгууллагыг бүхэлд нь биш төрийн байгууллагыг төлөөлж байгаа ажилтан, албан тушаалтны талаар өгч байгаа гомдол юм гэдгийг энэ сард гомдол гаргасан иргэдийн 90 орчим хувь нь зөрчил гаргасан албан тушаалтны нэрийг тодорхой хэлсэн нь, үлдсэн 10 хүрэхгүй хувь нь төрийн байгуулалын тодохой хүрээний албан тушаалтнуудыг хамруулж нэрлэсэн нь харуулж байгаа.

Зөрчил гаргасан албан тушаалтнуудыг авч үзвэл мэргэжилтэн, шинжээч, байгцаагчид зэрэг төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалтан болон цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч, ахлагч зэрэг төрийн тусгай гүйцэтгэх албан тушаалтан, болосврол, соёлын байгууллагуудын мэргэжилтэн зэрэг төрийн үйлчилгээний мэргэжлийн албан тушаалтанд иргэдийн талаас илүү хувь нь гомдол гаргасан.

Төрийн байгууллагад иргэдийн хандсон зорилго

Утсанд хандсан иргэдийн 12 хувь нь тодорхойлолт авах, 12 хувь нь хэрэг шийдүүлэх, 10 хувь нь бичиг баримт авах, бүрдүүлэх асуудлаар очсон гэж хариулсан болно. Мөн иргэдийн 13 хувь нь буюу 11 иргэн тухайн төрийн байгууллагад хандаагүй ба төрийн байгууллагын албан тушаалтны зөрчил гаргаж байгааг харсан, гэрчилж чадна гэж хэлсэн.

Гомдол гаргаж байгаа үндэслэл

Иргэдийн 29 хувь нь албан тушаалтнууд хүнд суртал чирэгдэлтэй, 27 хувь нь байгууллагын үйл ажиллагааны чиглэлдээ хамаарах асуудлыг авч хэлцэхгүй, 18 хувь нь байгууллагын үйл ажиллагааны дүрэм журам болон хуульд заасан хугацаандаа шийдвэрлэж өгөхгүй байна, 11 хувь нь албан тушаал, эрх мэдлээ ашиглаж улсын болон иргэдийн эд хөрөнгийг хувьдаа завшиж байна гэсэн үндэслэлээр гомдол гаргажээ.

Үүнийг төрийн байгууллагын цар хүрээгээр харьцуулбал улсны хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагууд хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй удах, хууль дүрмэнд заасны дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй, хүнд суртал гаргах, сум дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй, хууль дүүрмийн дагуу асуудлыг шийдэж өгөхгүй удах, хүнд суртал гаргах зэрэг зөрчилүүд элбэг тохиолдож байна.

Мөн үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл шүүхийн шийдвэр биелүүлэх газаруудад хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй байх, хүнд суртал гаргах, засаг даргын тамгын газруудад хууль дүрмэнд заасны дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байх, хүн суртал гаргах, албан тушаал эрх мэдлээ ашиглаж улсын болон бусдын эд хөрөнгийг хувьдаа завших, цагдаагийн газар албадад хууль дүрмийн дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байх, замын цагдаагийн газар албадад хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй удах, хууль дүрмийн дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байх, хүнд суртал гаргах, газрын албадад хууль дүрмийн дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байх, хүн суртал гагах явдал чирэгдэлтэй байх нь элбэг тохиолддог.

Тухайн байгууллагад хандаад зарцуулсан хугацаа

Утсанд хандсан иргэдээс тухайн байгууллага, албан тушаалтанд хандаад ямар хугацааг зарцуулж байгааг асуухад 37 хувь нь нэг сар болоогүй, 39 хувь нь 1-өөс 3 сар, 5 хувь нь 4-өөс 6 сар, 4 хувь нь 7 сараас нэг жил, 8 хувь нь 1-нээс 2 жил, мөн 7 хувь нь 2-оос дээш жил болсон гэж хариулсан.

Үүнийг байгууллагын цар хэмжээнд нь харьцуулбал сар болоогүй иргэдийн 40 хувь нь сум дүүргийн, 3 сар болоогүй иргэдийн 44 хувь сум дүүргийн, нэг жил болоогүй иргэдийн 66.7 хувь нь сум дүүрэг, хоёр жил болоогүй иргэдийн 60 хувь нь нийслэл, хоёроос дээш жил болж байгаа иргэдийн 50 хувь нь сум дүүргүүдийн төрийн байгууллагын албан тушаалтан нар иргэдийг хохироож байна. Үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл засаг даргын тамгын газар 3 сар хүртэлх хугацаанд, шүүхийн шийдвэр биелүүлэх газар 7-оос дээш хугацаанд газрын албад 1-ээс 3 сар, 2-оос дээш жил хүлээж байгаа иргэдийн олонх хувийг эзэлж байна.

Дээрхээс харахад тухайн байгууллагад хандсан иргэдийн 76 хувь нь тухайн байгууллагад хандаад 3 сар болоогүй байна гэж хариулсан нь зөвхөн хугацаа биш төрийн байгууллагыг төлөөлж байгаа албан тушаалтан нь шүүх цагдаагийн шийдвэрт нөлөөлсөн, хүнд суртал гаргах, ажилчдаа дарамтлах, хуулийн дагуу асуудлыг шийдэж өгөхгүй байх зэрэг бусад асуудлуудаар хандсан болно.

Иргэдийн саналын тухай мэдээлэл

Нийт 5 иргэн утсаар санал өгснөөс бүгд АТГ-т хандаж Оюу толгойн гэрээн дээр анхааралаа хандуулж өгөх, визний хугацаа нь дууссан хятад иргэдийг хуулиндаа өөрчлөлт оруулж шийдэж /хөөж гаргах/ өгөх, татварын албанд тайлангаа өгөхөд их чирэгдэлтэй байдаг учир татварын албаны байранд гурваас дөрвөн өрөө суллаж татварын хэлтэс дээр суугаа татварын ажилтныг ажилаас нь долоо хоногийн хугацаанд чөлөөлж өгөх, АТГ-ийн хуулинд олон улын жишигт үр дүнгээ харуулсан авилга авсаныг биш өгсөнийг шийтгэх тухай өөрчлөлт оруулах, нийслэлийн засаг даргын гаргасан урьдын шийдвэрүүдийг шалгаж өгөхийг хүссэн саналуудыг тавьсан байна.